



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2028 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/49

Булган

**Үзэсгэлэн худалдаа
зохион байгуулах тухай**

Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 17.2.2, 23.1.5, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны "Хөгжлийн хөтөч" хөтөлбөрийн 1.5.2.8, 2.3.2.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үндэсний уламжлалт "Цагаан сар"-ын баярыг угтаж аймгийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгч, малчид, ногоочдын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчилж, борлуулалтыг нэмэгдүүлэх, иргэдэд чанартай, экологийн цэвэр бүтээгдэхүүнээр үйлчлэх зорилго бүхий "Цагаан сар-Булган түншлэл-80" үзэсгэлэн худалдааг 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдрөөс 3 хоног аймгийн "Спортын ордон"-д зохион байгуулсугай.

2. Үзэсгэлэн худалдаа зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ц.Бат-Өлзий /Аймгийн Засаг даргын орлогч/

Ажлын хэсгийн орлогч дарга: Д.Буманбаяр /Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга/

Гишүүд: Ч.Оюун-Эрдэнэчимэг /Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн/

Ч.Амгалан /Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга/

Н.Батжаргал /Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга/

Б.Долгорсүрэн /Мэргэжлийн хяналтын газрын даргын үүргийг түр орлон

гүйцэтгэгч/

А.Ханддорж /Биеийн тамир, спортын газрын дарга/

Д.Наранбаяр /Булган сумын Засаг дарга/

М.Бадам /Стандарт, хэмжилзүйн хэлтсийн баталгаажуулалтын шинжээч/

Б.Батбаяр /Хүнс, хөдөө аж ахуйн газрын Жижиг, дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтэн/

Д.Мөнхбаасан /Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнсний үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн/

Ч.Оюунтуяа /МСҮТ-ын захирал/

С.Оюунбат /ХАА-н МСҮТ-ийн захирал/

Ц.Энхтуяа /Булган сумын Соёлын ордны эрхлэгч/

Г.Нарангэрэл /Булган сумын Жижиг, дунд үйлдвэр, худалдаа үйлчилгээ

хариуцсан мэргэжилтэн/

Ш.Бадамрагчаа /Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны ажилтан/

Д.Оюунгэрэл /Аймгийн Худалдаа аж үйлдвэрийн танхимийн дарга/

Д.Мэндсайхан /Ажил олгогч эздийн холбооны тэргүүн/

Нарийн бичгийн дарга: Ц.Бүрэнтуяа /Стандарт, хэмжилзүйн хэлтсийн дарга/

3. Үзэсгэлэн худалдаанд сум орон нутгийнхаа бизнес эрхлэгчдийг бэлтгэл сайтай өргөнөөр оролцуулах арга хэмжээг зохион байгуулж, эрхэлсэн ажлын хүрээнд шийдвэр гарган биелэлтийг нь тооцож ажиллахыг ажлын хэсэг, сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

З.БАТЗОРИГ

